



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 3-р сургуулийн  
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2024/153-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2024 он

Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: Цахим хаяг: [davaag@audit.gov.mn](mailto:davaag@audit.gov.mn)

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: [narantuyam@audit.gov.mn](mailto:narantuyam@audit.gov.mn)

Миндүг аудит ХХК-ийн захирал: С.Энхтөр

Утас: 95957791 Цахим хаяг: [director@mindug.mn](mailto:director@mindug.mn)

Аудитын менежер: Ц.Номингоо

Утас: 90098901 Цахим хаяг: [coo@mindug.mn](mailto:coo@mindug.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	<b>3</b>
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	<b>100</b>
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	<b>122</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2024.08.25 № 154  
танай \_\_\_\_\_ - ны/ныг \_\_\_\_\_ -т

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант хугацааны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх төсвийн төслийг улсын 2,877,890.9 мянган төгрөг, зарлагыг мөн 2,877,890.9 мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, улсын төсвөөс 1,899,907.3 мянга, орон нутгийн төсвөөс 249,235.6 мянган төгрөг батлагдсан байна. Батлагдсан төсвийг 10 дугаар сард 131,483.0 мянган төгрөгөөр нэмж, нийт 2,031,390.3 мянган төгрөг болгон нэмэгдүүлж тодотгосон байна.

### **Аудитын гол асуудал**

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 88,385.8 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үлдэгдлийг зарцуулаагүй, мөн 9,11,12-р сард хүнс, цалингийн зардал дээр Боловсролын Ерөнхий Газрын даргын 2023 оны 12-р сарын 25-ны өдрийн А/461

тоот тушаалаар санхүүжилт хийгдэж, жилийн эцэст зарцуулаагүйтэй холбоотой байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөрийн хүрээнд 12 арга хэмжээг төлөвлөж, 12 арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дээд шатны байгууллагаас 97.4 хувьтай үнэлж, дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>130,590,928.01</b>	<b>233,785,885.46</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>28,981,262.32</b>	<b>117,367,054.27</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	28,981,262.32	117,367,054.27
31210	Төгрөг	28,981,262.32	117,367,054.27
31211	Төрийн сангийн харилцах	28,981,262.32	117,367,054.27
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>101,609,665.69</b>	<b>116,418,831.19</b>
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	13,883,712.66	19,632,000.16
35400	Хангамжийн материал	87,725,953.03	96,786,831.03
35420	Аж ахуйн материал	12,500,653.00	10,469,140.00
35460	Хүнсний материал	221,856.00	2,108,262.00
35470	Бусад хангамжийн материал	75,003,444.03	84,209,429.03
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>1,490,736,764.39</b>	<b>1,510,759,606.94</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,490,736,764.39</b>	<b>1,510,759,606.94</b>
39200	Биет хөрөнгө	1,362,134,889.39	1,382,345,231.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,168,343,827.00	1,168,343,827.00
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(125,447,704.44)	(156,809,620.92)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	218,886,884.00	402,123,390.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(25,637,484.36)	(116,051,506.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,186,618.00	115,378,618.00
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(19,442,511.69)	(66,040,115.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,888,500.00	1,888,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(1,762,600.00)	(1,888,500.00)
39217	Номын фонд	43,119,360.88	35,400,640.06
39300	Биет бус хөрөнгө	128,601,875.00	128,414,375.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(78,125.00)	(265,625.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	127,180,000.00	127,180,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>1,621,327,692.40</b>	<b>1,744,545,492.40</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	<b>420,000.00</b>	<b>3,040,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>420,000.00</b>	<b>3,040,000.00</b>
41300	Өглөг	420,000.00	3,040,000.00
41360	Бусад өглөг	420,000.00	3,040,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	420,000.00	3,040,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>1,620,907,692.40</b>	<b>1,741,505,492.40</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,620,907,692.40</b>	<b>1,741,505,492.40</b>

51101	-Төрийн	152,616,000.00	152,616,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,389,450,932.59	1,510,048,732.59
51210	Өмнөх үеийн үр дүн	(231,456,759.81)	1,389,450,932.59
51220	Тайлант үеийн үр дүн	1,620,907,692.40	120,597,800.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	78,840,759.81	78,840,759.81
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>1,621,327,692.40</b>	<b>1,744,545,492.40</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,259,466,723.42	2,350,211,137.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,578,299,323.42	126,540,337.60
1200	Нийтлэг татварын бус орлого	1,578,299,323.42	126,540,337.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	170,065,790.00	27,973,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	5,601,400.00	6,173,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	16,850,000.00	21,800,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	147,614,390.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,312,069,720.73	92,479,935.10
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	96,163,812.69	6,086,702.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,681,167,400.00	2,223,670,800.00
1310	Улсын төсвөөс	1,429,590,000.00	1,974,435,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,974,435,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,429,590,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	251,577,400.00	249,235,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	251,577,400.00	249,235,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,638,559,031.02	2,219,463,281.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,638,559,031.02	2,219,463,281.68
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,523,741,126.02	2,067,762,586.41
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,073,177,977.00	1,455,567,267.58
210101	Үндсэн цалин	720,145,204.00	959,871,682.90
210102	Нэмэгдэл	296,460,526.00	443,808,474.98
210104	Урамшуулал	56,572,247.00	51,887,109.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,553,696.68	183,025,723.47
210201	Тэтгэврийн даатгал	91,997,813.26	125,276,184.36
210202	Тэтгэмжийн даатгал	10,872,852.97	14,788,614.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,627,804.28	12,285,682.96
210204	Ажилгүйдлийн даатгал	2,095,857.65	2,771,087.60
210205	Эрүүл мэндийн даатгал	20,959,368.52	27,904,154.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,482,567.00	192,704,304.73

210301	Гэрэл, цахилгаан	6,803,373.00	7,043,543.25
210302	Түлш, халаалт	176,240,599.00	173,392,265.48
210303	Цэвэр, бохир ус	19,438,595.00	12,268,496.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,561,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	610,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	3,951,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,664,400.00	16,088,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,601,400.00	6,173,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,063,000.00	9,915,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,862,485.34	215,814,790.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,093,429.00	36,851,573.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	14,990,210.00	10,276,275.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	48,778,846.34	168,686,942.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	114,817,905.00	151,700,695.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	112,394,300.00	125,589,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	97,338,000.00	110,302,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,056,300.00	15,286,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,423,605.00	26,111,295.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,423,605.00	26,111,295.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	1,620,907,692.40	130,747,855.92
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	10,150,055.92
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	10,150,055.92
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	10,150,055.92
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	1,620,907,692.40	120,597,800.00

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,703,618,800.00</b>	<b>2,251,644,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>22,451,400.00</b>	<b>27,973,700.00</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	22,451,400.00	27,973,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,451,400.00	27,973,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	5,601,400.00	6,173,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	16,850,000.00	21,800,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,681,167,400.00</b>	<b>2,223,670,800.00</b>
1310	Улсын төсвөөс	1,429,590,000.00	1,974,435,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,974,435,200.00

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,429,590,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	251,577,400.00	249,235,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	251,577,400.00	249,235,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>1,594,806,037.68</b>	<b>2,058,418,802.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,594,806,037.68</b>	<b>2,058,418,802.05</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,479,890,282.68	1,904,831,700.78
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,073,177,977.00	1,455,567,267.58
210101	Үндсэн цалин	720,145,204.00	959,871,682.90
210102	Нэмэгдэл	296,460,526.00	443,808,474.98
210104	Урамшуулал	56,572,247.00	51,887,109.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,553,696.68	183,025,723.47
210201	Тэтгэврийн даатгал	91,997,813.26	125,276,184.36
210202	Тэтгэмжийн даатгал	10,872,852.97	14,788,614.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,627,804.28	12,285,682.96
210204	Ажилгүйдлийн даатгал	2,095,857.65	2,771,087.60
210205	Эрүүл мэндийн даатгал	20,959,368.52	27,904,154.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,482,567.00	193,124,304.73
210301	Гэрэл, цахилгаан	6,803,373.00	7,043,543.25
210302	Түлш, халаалт	176,240,599.00	173,392,265.48
210303	Цэвэр, бохир ус	19,438,595.00	12,688,496.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,324,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,501,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	3,823,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,664,400.00	16,088,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,601,400.00	6,173,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,063,000.00	9,915,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,011,642.00	51,701,505.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,638,965.00	34,067,530.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	17,372,677.00	17,633,975.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	114,915,755.00	153,587,101.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	112,492,150.00	127,475,806.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	97,435,850.00	112,188,906.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,056,300.00	15,286,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,423,605.00	26,111,295.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,423,605.00	26,111,295.27
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>108,812,762.32</b>	<b>193,225,697.95</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>79,831,500.00</b>	<b>104,839,906.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>79,831,500.00</b>	<b>104,839,906.00</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	79,831,500.00	104,839,906.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	79,831,500.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	79,831,500.00	104,839,906.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>	<b>(79,831,500.00)</b>	<b>(104,839,906.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>	<b>28,981,262.32</b>	<b>88,385,791.95</b>
<b>14</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>28,981,262.32</b>
<b>15</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>28,981,262.32</b>	<b>117,367,054.27</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>152,616,000.00</b>	<b>78,840,759.81</b>	<b>1,140,757,643.45</b>	<b>1,372,214,403.26</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(1,372,214,403.26)	(1,372,214,403.26)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,616,000.00	78,840,759.81	(231,456,759.81)	
9	Тайлант үеийн үр дүн			1,620,907,692.40	1,620,907,692.40
<b>11</b>	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>152,616,000.00</b>	<b>78,840,759.81</b>	<b>1,389,450,932.59</b>	<b>1,620,907,692.40</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,616,000.00	78,840,759.81	1,389,450,932.59	1,620,907,692.40
<b>19</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>			<b>120,597,800.00</b>	<b>120,597,800.00</b>
<b>20</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>152,616,000.00</b>	<b>78,840,759.81</b>	<b>1,510,048,732.59</b>	<b>1,741,505,492.40</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,280,625,900.00</b>	<b>2,137,147,412.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,280,625,900.00</b>	<b>2,137,147,412.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,128,080,900.00</b>	<b>2,009,671,606.78</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,536,882,900.00</b>	<b>1,455,567,267.58</b>
210101	Үндсэн цалин	1,038,850,000.00	959,871,682.90
210102	Нэмэгдэл	431,823,200.00	443,808,474.98
210104	Урамшуулал	66,209,700.00	51,887,109.70

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	192,110,100.00	183,025,723.47
210201	Тэтгэврийн даатгал	130,634,700.00	125,276,184.36
210202	Тэтгэмжийн даатгал	15,368,900.00	14,788,614.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,295,100.00	12,285,682.96
210204	Ажилгүйдлийн даатгал	3,073,800.00	2,771,087.60
210205	Эрүүл мэндийн даатгал	30,737,600.00	27,904,154.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	219,235,600.00	193,124,304.73
210301	Гэрэл, цахилгаан	8,885,600.00	7,043,543.25
210302	Түлш, халаалт	192,850,000.00	173,392,265.48
210303	Цэвэр, бохир ус	17,500,000.00	12,688,496.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	30,000,000.00	30,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17,932,800.00	16,088,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,173,700.00	6,173,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,759,100.00	9,915,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	131,919,500.00	131,865,611.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	114,280,800.00	114,231,636.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,638,700.00	17,633,975.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	152,545,000.00	127,475,806.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	152,545,000.00	127,475,806.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	137,258,100.00	112,188,906.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,286,900.00	15,286,900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,252,652,200.00	2,223,670,800.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,252,652,200.00	2,223,670,800.00
122005	Орон нутгийн төсвөөс	2,223,670,800.00	2,223,670,800.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	28,981,262.32
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	6,173,700.00	6,173,700.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1 төлбөрийн акт хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөх саналтай байна.

#### 5.1 Төлбөрийн акт

Тус сургуулийн 1-5 дугаар ангийн суралцагчдын үдийн хоолны батлагдсан нормативд зардал, хүүхэд өдрөөр гарсан гүйцэтгэлийн зөрүүгээс үлдсэн 25,069.2 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг холбогдох дансанд төвлөрүүлэлгүй үлдэгдлээр илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 (Энэ хуулийн 38.1.2, 38.1.3-т заасан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсролын сургалтын байгууллага дараагийн төсвийн жил дамжин зарцуулж болно), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар зүйлийн 15.1.6 (нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх) гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

## **5.2 Зөвлөмж**

Илрүүлэлт: Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 3-р сургуулийн хүнсний материалын худалдан авалтыг ЗДТГ-аас тендер зарлаж оролцогч шалгаруулан хэрэгжүүлсэн. Бараа материалыг худалдан авахдаа тендерээр шалгарсан “Өсөхдэлгэр-Ундрах” ХХК-аас хүнсний бүтээгдэхүүн, гурил, будаа, сахар, хүнсний ногоо, бусад бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний дагуу худалдан авчээ. Уг гэрээг дүгнэсэн акт болон тооцоо нийлсэн зарим баримтуудыг бүрэн бүрдүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: хүнсний материалыг нийлүүлэх тендерээр шалгарсан байгууллагуудтай худалдан авалтын гэрээг дүгнэж, худалдан авалтын дүн, нэр төрөл болон ба тоо хэмжээнд хяналт тавьж ажиллахыг зөвлөж байна.

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 43 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Эдгээр хөрөнгүүдийг Өмч хамгаалах зөвлөлд танилцуулж, эд хөрөнгийн байдалтай уялдуулан цаашид ашиглах хугацааг тодорхойлон ашиглах боломжгүй болсон бол актлуулах, дахин үнэлгээ хийлгэх шаардлагатай.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн насжилт буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалтыг мөрдөн Орон нутгийн өмчийн газарт 43 нэр төрлийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн	
Үдийн цай хөтөлбөрөөс 25,069.2 мянган төгрөгийн гүйцэтгэл дуу, холбогдох дансанд төвлөрүүлээгүй	1	25,069.2	1	25,069,2	-	-	-	-	-	-	-	-	-
Худалдан авалтын гэрээ дүгнэж, акт үйлдээгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Анхны өртгөө нөхсөн 43 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлд байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Дүн	3	-	1	-	-	-	2	-	-	-	-	-	-